



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

146.	Монгол хэлбичгийн боловсролыг сайжруулах арга хэмжээний тухай	Дугаар 37	577
147.	Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 38	578
148.	Журам батлах тухай	Дугаар 41	580

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 2 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 37

Улаанбаатар
хот

Монгол хэлбичгийн боловсролыг сайжруулах арга хэмжээний тухай

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Иргэдийн эх хэлний боловсролын чанар, хэрэглээ, иргэдийн харилцааны соёлын түвшинг дээшлүүлэх, эх хэлний дархлааг сайжруулах зорилгоор дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөрт үүрэг болгосугай:

1.1. Бага насны хүүхдэд эх хэлийг сэтгэхүйг нь хөгжүүлэх сонирхолтой арга хэлбэрээр зааж үгийн сангийн нөөцийг нэмэгдүүлэх;

1.2. Ерөнхий боловсролын сургууль төгсөгч, их, дээд сургууль, коллежид элсэгчдээс монгол хэлбичгийн хичээлээр шалгалт авч байх журам тогтоон 2013-2014 оны хичээлийн жилээс эхлэн мөрдүүлэх;

1.3. Монгол кирил бичгийн үсгийн дүрмийг журамласан толь бичгийг шинэчлэн боловсруулж бүх нийтээр дагаж мөрдүүлэх, үсгийн дүрмийн алдаа засах программ боловсруулж, хэрэглээнд нэвтрүүлэх.



2. Төрийн албаны ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод монгол хэлбичгийн мэдлэгийн түвшинг харгалзах ур чадварын шаардлагыг нэмж тусгахыг Төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.

3. Сонин хэвлэл, мэдээллийн хэрэгслийн бүх нийтлэл, мэдээ, нэвтрүүлэг, зар сурталчилгааг монгол кирил бичгийн үсгийн дүрмийн шаардлага хангасан, утга зохиолын хэлний хэм хэмжээнд бүрэн нийцсэн байх шалгуурыг ханган олон нийтэд хүргэж, иргэдийн монгол хэлбичгийн мэдлэгийг дээшлүүлэх, эх хэлээрээ зөв оновчтой ярих, бичих чадварыг сайжруулахад нөлөөлөх хүчин зүйл болгон ажиллахыг тухайн байгууллагын удирдлага, нийт хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтнуудад зөвлөсүгэй.

4. Төрийн албан хэрэг хөтлөлтийн стандартыг бүх шатанд мөрдлөг болгож төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Хот, суурин газар төрийн болон хувийн хэвшлийн бүх байгууллагын хаяг, зар сурталчилгааг монгол кирил бичгээр бичиж байхыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Л.ГАНТӨМӨР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 2 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 38

Улаанбаатар
хот

Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болгосон болон Монгол Улсын Засгийн газарт олгосон гадаадын хандив, тусламж, зээлийн эх үүсвэрээр санхүүжиж байгаа төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн



хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчид шилжүүлэх, бүртгэх, холбогдох байгууллагын балансад бүртгэх арга хэмжээ авахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга, төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.

2. Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрын байршиж буй Монгол Улсын өмчлөлд байгаа газар, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг Монгол Улсын болон суугаа орны холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрт нийцүүлж баталгаажуулан зах зээлийн үнэлгээг тогтоож санхүүгийн тайланд тусгах, эд хөрөнгө түрээслэх болон хөдлөх үндсэн хөрөнгийг шинээр олж авах, шилжүүлэх, худалдах, акталж устгах асуудлыг зохицуулсан журам боловсруулж Засгийн газарт танилцуулахыг Гадаад харилцааны сайд Л.Болд, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга нарт даалгасугай.

3. Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг бүртгэх арга хэмжээг жил бүр зохион байгуулж байхыг Эрүүл мэндийн сайд Н.Удвал, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Улс, орон нутгийн музей болон холбогдох мэргэжлийн байгууллагын эзэмшилд байгаа үнэлгээ хийгээгүй хосгүй үнэт болон үнэт, ердийн зэрэглэлийн төрийн өмчийн түүх, соёлын дурсгалт зүйлсийн үнэлгээг тогтоох арга хэмжээ авахыг Соёл, спорт, аялал жуулчлалын сайд Ц.Оюунгэрэл, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Орон нутгийн чанартай зам, гүүрийг эзэмших бүртгэлийг нь хариуцах байгууллагыг тогтоож, хөрөнгө оруулалт, их засвар, өргөтгөл болон шинэчлэл, өөрчлөлтийг тухай бүр бүртгэлд тусгуулж байх ажлыг зохион байгуулахыг Зам, тээврийн сайд А.Гансүх, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга нарт даалгасугай.

6. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах талаар гарсан шийдвэрт өөрчлөлт оруулах тухай бүрт Барилга, хот байгуулалтын яам, Төрийн өмчийн хороотой урьдчилан зөвшилцөж, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах талаар гарсан шийдвэрт өөрчлөлт оруулахдаа аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.



7. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг 2013 оны III улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулгад даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ
АЖ АХУЙН САЙД**

Х.БАТТУЛГА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 2 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 41

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Олимп, тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах журам”-ыг 1 дүгээр, “Медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнах мөнгөн шагналын хэмжээ”-г 2 дугаар, “Үндэсний хэмжээний тэмцээний мөнгөн шагналын хэмжээ, түүнийг олгох журам”-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Мөнгөн шагналд шаардагдах хөрөнгийг жил бүр төсвийн багцдаа тусган санхүүжүүлж байхыг Соёл, спорт, аялал жуулчлалын сайд Ц.Оюунгэрэлд үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2009 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 326 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Ц.ОЮУНГЭРЭЛ

Засгийн газрын 2013 оны 41 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

**ОЛИМП, ТИВИЙН НААДАМ, ДЭЛХИЙН ЗЭРЭГЛЭЛИЙН
ТЭМЦЭЭНД АМЖИЛТТАЙ ОРОЛЦОЖ МЕДАЛЬ ХҮРТСЭН
ТАМИРЧИН, ТҮҮНИЙ ДАСГАЛЖУУЛАГЧИЙГ
ШАГНАЖ УРАМШУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Олимп, тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн тэмцээнд сонирхогчдын спортын төрлөөр оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг Засгийн газраас мөнгөн шагналаар шагнаж урамшуулахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

2. Тэмцээний ангилал, зэрэглэл, тухайн жин, зай, төрөлд оролцсон орны тооноос хамааран тамирчин, дасгалжуулагчид дор дурдсан хувь хэмжээний мөнгөн шагналыг олгоно:

Тэмцээний		Жин, зай, төрөл тус бүрт оролцсон орны тоо		Олгох мөнгөн шагналын хувь хэмжээ
Ангилал	Зэрэглэл	Эрэгтэй	Эмэгтэй	
1. Олимп, дэлхий, тивийн спортын их наадмын хөтөлбөрт орж зохиогдсон спортын төрлийн тэмцээн	Олимпийн наадам	Оролцогч орны тоо харгалзахгүй		100%
	Паралимпийн наадам			
	Дифлимкийн наадам	10-15	7-8	100%
		6-9	5-6	60%
		5 хүртэлх	4 хүртэлх	30%
	Универсиад наадам, Дэлхийн наадам	32 болон түүнээс дээш	24 болон түүнээс дээш	100%
		21-31	17-23	60%
		20 хүртэлх	16 хүртэлх	30%
	Азийн наадам	16 болон түүнээс дээш	12 болон түүнээс дээш	100%
		12-15	9-11	60%
11 хүртэлх		8 хүртэлх	30%	



2. Олимпийн их наадмын хөтөлбөрт ордог спортын төрлийн тэмцээн	Дэлхийн аварга	32 болон түүнээс дээш	24 болон түүнээс дээш	100%
		21-31	17-23	60%
		20 хүртэлх	16 хүртэлх	30%
	Дэлхийн хэмжээний цуврал тэмцээн	24 болон түүнээс дээш	17 болон түүнээс дээш	100%
		17-23	12-16	60%
		17 хүртэлх	11 хүртэлх	30%
	Ази тивийн аварга	16 болон түүнээс дээш	12 болон түүнээс дээш	100%
		12-15	9-11	60%
		11 хүртэлх	8 хүртэлх	30%
3. “Спорт Аккорд” олон улсын спортын холбоонд элссэн төрлийн спортын тэмцээн*	Дэлхийн аварга	26 болон түүнээс дээш	22 болон түүнээс дээш	100%
		19-25	16-21	60%
		18 хүртэлх	15 хүртэлх	30%
	Дэлхийн цом	24 болон түүнээс дээш	20 болон түүнээс дээш	100%
		17-23	14-19	60%
		16 хүртэлх	13 хүртэлх	30%
4. Бусад спортын төрөл	Дэлхийн аварга	22 болон түүнээс дээш	18 болон түүнээс дээш	100%
		15-21	12-17	60%
		14 хүртэлх	11 хүртэлх	30%

* Тайлбар: “Спорт Аккорд”-д зуны төрлөөр 3 тивийн 40-өөс дээш оронд, өвлийн төрлөөр 2 тивийн 25 оронд хөгжсөн олимпийн бус спортын 55 төрөл хамрагддаг.



3. Дэлхийн цомын төлөөх шигшээ тэмцээнд тив, бүс нутгийг төлөөлж нэр заагдан уригдан оролцож медаль хүртсэн тамирчинд оролцогч орны тоог харгалзахгүйгээр мөнгөн шагналын 30 хувийг олгоно.

4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчинд энэхүү журмын 2 дахь заалтад заасан тэмцээний ангилалд ногдох мөнгөн шагналыг олгоно.

5. Дэлхийн хэмжээний цувралаар явагддаг тэмцээн (Грандслам, Гранпри, Дэлхийн цом) тус бүрт тамирчны үзүүлсэн хамгийн өндөр амжилтаар тооцож мөнгөн шагналыг тухайн жилд нэг удаа олгоно.

6. Багийн спортын төрлөөр медаль хүртсэн багийн тамирчин тус бүрт оролцсон орны тоог харгалзахгүйгээр медальд ногдох мөнгөн шагналын 50 хувийг олгоно.

7. Тамирчны тэмцээнд оролцсон зай, жин, төрөл тус бүрд авсан медальд харгалзах мөнгөн шагналыг олгоно. Спортын төрөл доторхи багийн тэмцээнд медаль хүртсэн тохиолдолд энэ журмын 6 дахь заалтын дагуу мөнгөн шагналыг олгоно.

8. Шатар, зуун буудалт даамын төрлөөр олон улсын их мастер (Гроссмейстер)-ын цол хүртсэн тамирчинд тивийн наадмын алтан медальд ногдох мөнгөн шагналыг олгоно.

9. Медаль хүртсэн тамирчинд ногдох мөнгөн шагналын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагналыг дасгалжуулагчид олгоно.

10. Мөнгөн шагнал авах болзол хангасан тамирчин эсхүл багтай 1-ээс дээш дасгалжуулагч ажилласан тохиолдолд дасгалжуулагчдад олгох мөнгөн шагналыг дараахь хувийг харгалзан хуваарилна:

Дасгалжуулагч	Олгох мөнгөн шагналын хувь
Анхны багш болон дасгалжуулагч	10-15 хувь
Үндсэн дасгалжуулагч	30-50 хувь
Бусад дасгалжуулагч (шигшээ багийн г.м)	20-35 хувь



11. Спортын байгууллага, холбоод наадам, тэмцээнд оролцохоос 14-өөс доошгүй хоногийн өмнө багийн бүрэлдэхүүнийг биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад уламжлан шийдвэр гаргуулна. Багийн бүрэлдэхүүнийг батлуулахдаа дараахь материалыг бүрдүүлнэ:

11.1. тухайн тэмцээний нэр, хугацаа, болох газрыг заасан албан ёсны урилга;

11.2. тэмцээний заавар, журам албан ёсны орчуулгын хамт;

11.3. овог нэр, нас, хүйс, оролцох зай, жин, эмчийн магадлагаа бүхий тамирчдын мэдүүлэг;

11.4. дасгалжуулагчдын мөнгөн шагналын хуваарилалт бүхий гэрээг ирүүлнэ.

12. Мөнгөн шагнал авах болзол хангасан тамирчин, дасгалжуулагчийн хамаарах спортын байгууллага, холбоо нь биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад дараахь материалыг тэмцээн дууссанаас хойш 21 хоногийн дотор ирүүлсэн байх үүрэгтэй:

12.1. тамирчныг мөнгөн шагналаар шагнуулах хүсэлт;

12.2. тэмцээнд медаль авсныг нотолсон тэмцээний протокол, баримт, диплом, гэрчилгээ, медалийн хуулбарын хамт (орчуулсан байх);

12.3. тухайн тэмцээний мэдээлэл, протоколыг байрлуулсан интернэтийн вэб сайтын нэр, хаяг, танилцуулга;

12.4. залуучууд, өсвөр үеийнхний тэмцээнд оролцсон тамирчдын төрсний гэрчилгээ болон иргэний үнэмлэхийн хуулбар;

12.5. хугацаа хоцорсон материалыг хүлээн авахгүй.

13. Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага энэхүү журмын 12 дахь хэсэгт заасан материалыг хянаж, мөнгөн шагнал олгох тухай саналаа Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ.



14. Тамирчин, түүний дасгалжуулагчид мөнгөн шагнал олгох Засгийн газрын шийдвэрийг үндэслэн биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага мөнгөн шагналыг олгож, мэдээллийн сан бүрдүүлнэ.

15. Энэхүү журам нь зөвхөн Монгол Улсын иргэнд хамаарна.

16. Тамирчин допинг хэрэглэсэн нь тогтоогдож медалиа хураалгасан тохиолдолд урамшуулал олгохгүй бөгөөд олгосны дараа илэрвэл мөнгөн шагналыг тамирчин болон түүний дасгалжуулагчаар нөхөн төлүүлнэ.

17. Тэмцээний материалыг хуурамчаар бүрдүүлсэн тохиолдолд тухайн этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Засгийн газрын 2013 оны 41 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

**МЕДАЛЬ ХҮРТСЭН ТАМИРЧИН, ТҮҮНИЙ ДАСГАЛЖУУЛАГЧИЙГ
ШАГНАЖ УРАМШУУЛАХ МӨНГӨН ШАГНАЛЫН ХЭМЖЭЭ**

(сая.төг)

№	Тэмцээний		Мөнгөн шагналын хэмжээ (тамирчдын насны ангилал, медалиар)								
	Ангилал	Зэрэглэл	Насанд хүрэгчид			Залуучууд (оюутан)			Өсвөр үе		
			Алт	Мөнгө	Хүрэл	Алт	Мөнгө	Хүрэл	Алт	Мөнгө	Хүрэл
1	Олимп, дэлхий, тивийн спортын их наадмын хөтөлбөрт орж зохиогдсон спортын төрлийн тэмцээн	Олимпын наадам	120.0	60.0	30.0	-	-	-	40.0	20.0	10.0
		Паралимпын наадам	120.0	60.0	30.0	-	-	-	-	-	-
		Дифлимпын наадам	60.0	30.0	10.0	-	-	-	-	-	-
		Универсиад наадам	30.0	15.0	10.0	-	-	-	-	-	-
		Дэлхийн спортын наадам	15.0	8.0	4.0	-	-	-	-	-	-
		Азийн наадам	30.0	15.0	10.0	-	-	-	6.0	4.0	3.0
2	Олимпын их наадмын төрлийн спортын тэмцээн	Дэлхийн аварга	40.0	25.0	20.0	12.0	8.0	6.0	6.0	4.0	3.0
		Дэлхийн хэмжээний цуврал тэмцээн	20.0	15.0	10.0	-	-	-	-	-	-
		Тивийн аварга	10.0	8.0	7.0	7.0	5.0	3.0	3.0	2.0	1.0



3	"Спорт Аккорд" олон улсын спортын холбоонд элссэн төрлийн спортын тэмцээн	Дэлхийн аварга	7.0	5.0	4.0	4.0	3.0	2.0	3.0	2.0	1.0
		Дэлхийн цом	4.0	3.0	2.0	-	-	-	-	-	-
4	Бусад төрөл	Дэлхийн аварга	4.0	3.0	2.0	3.0	2.0	1.0	2.0	1.0	0.5

Засгийн газрын 2013 оны 41 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

**ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ ТЭМЦЭЭНИЙ
МӨНГӨН ШАГНАЛЫН ХЭМЖЭЭ,
ТҮҮНИЙГ ОЛГОХ ЖУРАМ**

1. Үндэсний хэмжээнд зохион байгуулж байгаа монголын бүх ард түмний, хүүхдийн, оюутны, үндэсний спортын их наадам, улсын аварга шалгаруулах тэмцээн (цаашид "тэмцээн" гэх)-д амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг мөнгөн шагналаар шагнаж урамшуулахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

2. Медаль хүртсэн тамирчинд дор дурдсан хэмжээний мөнгөн шагнал олгоно:

№	Тэмцээний		Медалийн төрөл	Мөнгөн шагналын хэмжээ (мян.төг)
	Ангилал	Зэрэглэл		
1	Спортын их наадам	Монголын бүх ард түмний	Алт	1500.0
			Мөнгө	1000.0
			Хүрэл	500.0
		Оюутны, үндэсний, хүүхдийн	Алт	600.0
			Мөнгө	400.0
			Хүрэл	200.0



2	Улсын аварга	Насанд хүрэгчид	Алт	600.0
			Мөнгө	400.0
			Хүрэл	200.0
		Залуучууд, Өсвөр үе	Алт	400.0
			Мөнгө	200.0
			Хүрэл	100.0

3. Тэмцээнд багийн нийлбэр дүнгээр медальт байранд шалгарсан багийн дасгалжуулагчид энэхүү журмын 2 дахь заалтад заасан тэмцээний ангилалд ногдох мөнгөн шагналыг олгоно.

4. Багийн спортын төрлөөр медаль хүртсэн багийн тамирчин тус бүрт тухайн медальд ногдох мөнгөн шагналын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагналыг олгоно.

5. Хөнгөн атлетик, тэшүүр, буудлага зэрэг хэмжигдэхүүнээр амжилтыг нь тооцдог спортын төрлөөр Монгол Улсын рекорд амжилтыг шинэчлэн тогтоосон тохиолдолд тамирчинд олгох мөнгөн шагналыг 30 хувиар нэмэгдүүлэн олгоно.

6. Тэмцээн зохион байгуулсан спортын холбоо нь биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тэмцээний тайлан, протоколыг тэмцээн дууссанаас хойш 14 хоногийн дотор ирүүлнэ.

7. Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага спортын холбоодоос ирүүлсэн тэмцээний протокол, тайланг хянаж, мөнгөн шагналыг эрхэлсэн сайдын шийдвэрээр олгоно.

8. Дараахь тохиолдолд мөнгөн шагналыг олгохгүй:

8.1. тэмцээний протокол, тайлан, тамирчинд олгох шагналтай холбоотой материалын бүрдэл дутуу;

8.2. материалыг хугацаанд нь ирүүлээгүй;

8.3. өсвөр үе, залуучуудын тэмцээнд нас дарж орсон.

9. Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тамирчин, дасгалжуулагчид мөнгөн шагналыг олгож, мэдээллийн сан бүрдүүлнэ.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 0.75

Индекс: 14003